



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/673

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.7, 15.9, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль, эрх зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны ээлжит XVIII хуралдааны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээдийн хүсэлт, ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал), аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



П.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012072

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСААЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28-ны өдрийн
А/С.Б.дугаар захирамжийн хавсралт



№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Утасны дугаар	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Хуулийн этгээдийн нэр	Байршил		
1	Тосон өнөр ХХК	Тосонцэнгэл сум 5-р баг Аргалант 11-12а тоот "Өнөр" мини маркет	88509955	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх
2	Тэмээн ХХК	Мөрөн сум 8-р баг "Барилгачин" зоогийн газар	99101138	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх
3	Их хорлын буян ХХК	Улаан-Уул сум 5-р баг "Буянт" зоогийн газар	93058080	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
4	Түвшинтайжууд ХХК	Мөрөн сум 1-24-01 тоот "Ундраг" хүнсний дэлгүүр	88387305	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
5	Галт мансэ ХХК	Мөрөн сум 8-р баг 112-р байр "Руу" лоунжэ ресторан	89893196	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
6	Дэлгэрэх айзам" ХХК	Түнэл сум 7-1 тоот "Аривжих" хүнсний дэлгүүр	89381422	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
7	Түнэл Тэрхэн Цагаан-Уул ХХК	Мөрөн сум 11-43-01 тоот "Тэрхэн Цагаан-Уул" хүнсний дэлгүүр	88386684	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
8	Өсөх Прогресс ХХК	Мөрөн сум 13-р баг Шинэ мөрөн худалдааны төв "89 архи, ундааны" бөөний төв	91918002	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

9	Анх Цэн ХХК	Мөрөн сум 10- тоот “Оргилуун” хүнсний дэлгүүр	88779077	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
---	-------------	--	----------	--

_____ооо_____